МОНГОЛ УЛС: ЭДИЙН ЗАСАГ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ХҮЧИН ЗҮЙЛС ХӨВГҮҮДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТАД НӨЛӨӨЛЖ БАЙНА


Монгол Улсад охидын дунд боловсролын сургуульд хамрагдалт болон төгсөлтийн хувь хөвгүүдийнхээс тогтмол өндөр байсаар ирсэн. Социалист нийгмийн тогтолцооноос шилжсэн 1990-ээд оны үед энэ ялгаа нэмэгдэж, 2000 онд бүрэн дунд боловсрол эзэмшсэн 100 охин тутамд ердөө 61 хөвгүүн ногдож хамгийн өндөр түвшинд хүрсэн. 1997 онд хөвгүүдийн 47% нь суурь боловсрол эзэмшсэн бол охидын 64% нь эзэмшсэн. 2000 онд хөвгүүдийн ердөө 23% нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн бол охидын 39% нь эзэмшсэн байна. Үүнээс хойш төгсөлтийн хувь мэдэгдэхүйц өсөж, суурь боловсролын түвшинд жилд 1.7 хувийн пунктээр нэмэгдсэнээр 2022 онд төгсөлт бүх нийтийг хамарсан түвшинд хүрч, хүйсийн тэгш харьцаа хангагдсан бол бүрэн дунд боловсролын түвшинд жилд 2.4 хувийн пунктээр өсөж, хүйсийн тэгш харьцаанд аажмаар ойртож байна (Зураг 1). 2024/25 оны хичээлийн жилд нийт суралцагчдын дунд хөвгүүдийн эзлэх хувь бага болон суурь боловсролд 51%, бүрэн дунд боловсролд 46% байв. Бүрэн дунд боловсролд хамрагдсан нийт суралцагчдын дунд хөвгүүдийн эзлэх хувь зүүн бүсэд хамгийн бага буюу 42% байжээ (Монгол Улсын Боловсролын яам, 2025b).

Хүйсийн энэхүү ялгааг нүүдэлчин уламжлал, хөдөлмөрийн эрэлт хэрэгцээ, хөвгүүдийн суралцахаас илүү хөдөлмөр эрхлэхийг чухалчилдаг жендэрийн хэм хэмжээ зэрэг нөхцөл байдлын олон хүчин зүйлээр тайлбарлаж болно. Хөдөө орон нутагт мал маллах, улирлын нүүдэл хийх, ургац хураах ажилд хөвгүүдийн хөдөлмөрт түшиглэж ирсэн. Хот суурин газарт хөвгүүдийг сургуулиас нь гаргаж, албан бус уул уурхай, барилга, тээврийн салбарт ажиллуулах тохиолдол байсаар ирсэн. Хөвгүүд багаасаа тэсвэр хатуужилтай, бие даасан байж, эдийн засгийн хувь нэмэр оруулах ёстой гэж үздэг нийгмийн хэм хэмжээ энэ хэв шинжийг улам бэхжүүлдэг (Монголын Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2024).


ЗУРАГ 1:

Монгол Улсад хүйсийн ялгаа маш их байсан үеийн дараа дунд боловсролын түвшинд хөвгүүдийн үзүүлэлт охидын түвшинд ойртож байна

a. Дунд боловсролын төгсөлтийн хувь, хүйс болон боловсролын түвшнээр, Монгол Улс, 1990–2024 он



b. Дунд боловсролын төгсөлтийн хувийн хүйсийн тэгш харьцааны индекс, боловсролын түвшнээр, Монгол Улс, 1990–2024 он



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Mongolia_fig1

Эх сурвалж: ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгийн мэдээллийн сан.

Соёлын уламжлал энэ асуудлыг улам хүндрүүлж ирсэн. Зарим бүс нутагт хөвгүүд лам болохоор эсвэл хурдан морины унаачаар бэлтгэгдэхээр сургуулиас гардаг бөгөөд хурдан морь унах уламжлал нь үндэсний өвөрмөц төрхтэй гүн холбоотой. Хурдан морины унаач хүүхдийн бүртгэлд 16,000 орчим хөвгүүн унаач хүүхдээр бүртгэгдсэн байна. Хүүхдийн хөдөлмөрийн үндэсний судалгаагаар 2022 онд 5–17 насны хүүхдүүдийн 35% нь ямар нэг хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байсан, тэдний 83% нь хөвгүүд байжээ. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртсөн хүүхдүүдээс үүл үүрхай, барилга, ачаа өргөх, буулгах ажил эрхэлж байсан хүүхдүүд бараг бүгд хөвгүүд байв (ОУХБ болон Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, 2024). Хөвгүүд сургууль завсардах түгээмэл дурдагддаг нэг шалтгаан нь сургуулийн боловсролыг ач холбогдол багатай гэж үзэх явдал бөгөөд сургуулийн боловсрол нь эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд зонхилсон хэвээр байгаа, ялангуяа биеийн хүчний, олборлох салбарын болон тээвэртэй холбоотой ажил, амьжиргааны хэв маягтай төдийлөн уялддаггүй гэж үздэг.

Монгол Улсын боловсрол дахь хүйсийн тэгш харьцаанд хүрэх ахиц нь хүмүүсийн амьжиргаа, шилжилт хөдөлгөөний хэв шинж, сургуульд суралцахын ач холбогдлын талаарх ойлголтыг өөрчилсөн эдийн засаг, хүн ам зүй, үүр амьсгалын томоохон өөрчлөлттэй холбоотой байна. 1990-ээд он Монгол Улсын боловсролын тогтолцоонд ихээхэн хүндрэл, доголдол дагуулсан үе байв. 1991 онд эхэлсэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үйл явц өмнө нь бүх нийтийн, үнэ төлбөргүй бага болон дунд боловсролыг баталгаажуулж байсан бүтцийг задалсан. Улсын санхүү гүн хямралд орж, хөдөөгийн сургуулиуд дампуурч, багш нар цалингаа авахгүй байх нь түгээмэл болж, заримдаа цалинг нь шүүдай гурил, махаар орлуулан олгож байв (Suprunova, 2007).

Түүнээс хойш эдийн засаг эрчимтэй сэргэжээ. Уул уурхай, барилгын салбар хурдацтай өсөж, үндэсний эдийн засагт оруулах хувь нэмрээрээ хөдөө аж ахуйн салбарыг давсан байна (Gombodorj and Pető, 2022). ДНБ-д эзлэх татварын орлогын хувь 1998 онд 8% байснаа 2006 онд 29% болж өсөж, түүнээс хойш өнөөг хүртэл 25% орчимд хадгалагдаж, төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд хувь нэмэр оруулж иржээ. Боловсролын салбарт зарцуулсан төсвийн зардал ДНБ-ий 4%-аас тогтмол дээгүүр байсан боловч нийт төсвийн зарлагад эзлэх хувь нь 2015-2020 онд 15%-аас 10% болж аажмаар буурч, КОВИД-19 цар тахлын дараах 2022 онд 7.5% хүртэл бууraад 2023, 2024 онд дахин 10%-аас дээш гарсан байна. Засгийн газрын хөрөнгө оруулалтаар дэд бүтцийг өргөжүүлж, багш нарын цалинг тогтворжуулан, сургуулийн боловсролд итгэх итгэлийг сэргээжээ. Хөдөлмөрийн зах зээл төрөлжин хөгжихийн хэрээр боловсрол эзэмшсэний үр өгөөж илүү тодорхой болж, хүүхдээ дунд болон дунд боловсролын дараах түвшинд үргэлжлүүлэн сургах эцэг эхийн эрэлт нэмэгдсэн байна (Engel et al., 2014).

Зөвхөн эдийн засгийн сэргэлтээр боловсрол дахь хүйсийн тэгш харьцаанд ойртсон энэхүү өөрчлөлтийг бүрэн тайлбарлахгүй бөгөөд энэ нь эдийн засаг, нийгмийн илүү өргөн хүрээний өөрчлөлтийн үр дүн юм. Монгол Улсын хүн ам олон зууны турш сийрэг суурьшиж, нүүдлийн мал аж ахуй эрхлэн, улирлаар нүүдэллэж амьжиргаагаа залгуулж ирсэн. Харин энэ амьдралын хэв маяг эдүгээ ихээхэн дарамтад ороод байна. Бэлчээрийн даац хэтрүүлэн ашигласнаас доройтжээ. Уур амьсгалын өөрчлөлт зудын давтамжийг нэмэгдүүлж, зуны гангийн дараа хатуу ширүүн өвөл залгаж, мал сүргийг олноор хорогдуулан, хүмүүсийн амьжиргааг сүйтгэдэг энэхүү гамшигт мөчлөг улам ойр ойрхон тохиолдох болжээ (Khulan, 2024; Loo et al., 2022). Үүний үр дүнд хөдөөгөөс хот руу чиглэсэн өргөн хүрээтэй шилжилт хөдөлгөөн бий болжээ. 1960 онд Монголын 10 хүн тутмын бараг 6 нь хөдөө орон нутагт амьдарч байсан бол өнөөдөр гуравны нэг орчим нь л хөдөө амьдарч байна (World Urbanization Prospects, 2025). Олон малчин нүүдлийн мал аж ахуйг бүрмөсөн орхиж, ажил, боловсрол, үйлчилгээний боломж эрэлхийлэн Улаанбаатар хотод шилжин суурьшжээ. Албан ёсоор шилжин суурьшсан иргэдийн зэрэгцээ хотын захад төлөвлөлт, зохицуулалтгүй гэр хорооллууд олноор бий болсон бөгөөд энд гэрт амьдардаг ч эрх зүйн бүрэн статусгүй эсвэл төрийн үйлчилгээг бүрэн хүртэх боломжгүй гэр бүлүүд суурьшжээ (Batkhuyag and Dondogdulam, 2018; Burchard-Dziubińska et al., 2025).

Боловсрол нь энэхүү шилжилт хөдөлгөөнийг өдөөх хүчин зүйл төдийгүй түүний үр дагавар юм. Бага насны хүүхдүүдийг алслагдсан дотуур байртай сургуульд явуулдаг уламжлал нь гэр бүлээрээ нүүх, нэмэлт зардал гаргах эсвэл гэр бүл тусдаа амьдрахад өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүд бага насны хүүхдүүдээ дагуулан засаг захиргааны төвд очиж, харин эрэгтэйчүүд малаа маллахаар нутагтаа үлдэхэд олонтоо хүргэдэг байна (Ahearn-Ligham, 2016). 2024 онд судалгаанд хамрагдсан шилжин суурьшсан 500 өрхийн 39% нь шилжилт хөдөлгөөнийхөө гол шалтгааны нэгээр боловсролыг дурдсан бөгөөд илүү сайн дунд сургууль, дээд боловсролын байгууллагад суралцах боломжтой болохын тулд нүүн шилжсэн байна (Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сан болон Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, 2025).

Боловсролын тогтолцоог хөдөөгийн амьдралын нөхцөлд нийцүүлэн зохион байгуулсан байв. Зөвлөлтийн үед дотуур байртай сургуулийн өргөн сүлжээний ачаар нүүдэлчин өрхийн хүүхдүүд боловсрол эзэмших боломжтой болж, гэр бүл нь мал аж ахуйгаа үргэлжлүүлэн эрхэлдэг байжээ. Харин 1991 оноос хойш дотуур байрны нөхцөл байдал хурдацтай доройтсон байна. Төсвийн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор 1990-ээд оны дунд

үеэс төлбөртэй болгосноор суралцагчдын хамрагдалт огцом буурч, үлмаар Засгийн газар энэ шийдвэрээсээ буцаж, дотуур байраар үнэ төлбөргүй хангагдах эрхийг хуулиар дахин баталгаажуулахад хүрчээ (Batkhuyag and Dondogdulam, 2018). Дотуур байранд амьдардаг хүүхдийн тоо буурч байсан боловч 2014 оноос хойш тогтворжиж, эдүгээ дотуур байранд орох хүсэлт гаргасан хүүхдүүдийн дийлэнх нь байраар хангагдаж байна (Зураг 2a). Суурь боловсролын түвшинд дотуур байранд амьдардаг хөвгүүдийн тоо охидынхоос олон байдаг бол хот суурин газрын 10–12 дугаар ангид дотуур байранд амьдардаг охидын тоо хөвгүүдийнхээс хавьгүй олон байна (Зураг 2b).

Дотуур байр нь хөдөөгийн хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй хэвээр байна. Дотуур байранд орохыг хүсэлт гаргасан хүүхдүүдийн 75% гаруй нь малчин өрхийн хүүхдүүд байна (Монгол Улсын Боловсролын яам, 2025d). Гэвч дотуур байрны чанар жигд бус хэвээр байна. Дотуур байртай сургуулийн орчинд тавих барилга байгууламж, суралцагч, багш нарт зориулсан байр, анги танхимын хэмжээ, хоол хүнс, шим тэжээл, аюулгүй байдлын шаардлагыг хамарсан цогц стандартуудыг тогтоосон байна. Гэсэн хэдий ч дотуур байрны орчин дахь хүүхдүүдийн туршлагад хийсэн судалгаа, шинжилгээнүүд амьдрах нөхцөл хангалтгүй байгааг тогтмол харуулж байна. Дотуур байранд амьдардаг хүүхдүүд гэр бүлтэйгээ амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад стресс, түгшүүр, нойрны хүндрэл илүү их тохиолддог гэж мэдээлсэн байна. Амьдрах орчин нөхцөл тааруу байх нь сургууль завсардалтын түвшин өндөр байхад нөлөөлдөг (Монголын Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2024). Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны өнөөгийн нөхцөл байдал, багтаамжийг тодорхойлох судалгаагаар эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо, хамтын ажиллагаа хангалтгүй, материаллаг нөхцөл, төсөв хүрэлцээгүй, хүүхдийн тоо хэт олон байгаа нь дотуур байрны менежментэд хүндрэл учруулж байгааг тогтоожээ (Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн болон НҮБ-ын Хүүхдийн сан, 2025).


Хөдөө орон нутгийн сургалтын чанарыг сайжруулахын тулд цалингийн урамшуулал олгох, эмэгтэйчүүд дийлэнх болсон багшийн мэргэжилд эрэгтэйчүүдийг татан оролцуулах санаачилга хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ авч иржээ. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлээр сургуулийн боловсролыг хөдөөгийн амьдралтай илүү уялдуулахыг мөн зорьж, мал аж ахуй, хүрээлэн буй орчны шинжлэх ухаан, үүр амьсгалын талаарх мэдлэг, ойлголт, санхүүгийн боловсролыг хөтөлбөрт тусгасан байна. Малчин өрхүүдэд бичиг үсгийн болон амьдрах ухааны ур чадвар эзэмшүүлэх албан бус боловсролын арга хэмжээний үнэлгээгээр суралцагчдын 5% нь албан боловсролын дунд сургуульд эргэн хамрагдаж, 47% нь дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр бага болон дунд боловсролоо үргэлжлүүлсэн байна (UNESCO, 2022).

Харин хот суурин газрын тулгамдсан асуудлуудыг хангалттай шийдвэрлэж чадаагүй хэвээр байна. Монгол Улсад хотжилт хурдацтай, ихэнхдээ төлөвлөлтгүй явагдсан нь сургуулийн дэд бүтцийн хүчин чадалд хэт их ачаалал учруулжээ. 2024/25 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 885 сургууль байсны 314 нь нийслэл Улаанбаатар хотод байв. Энэ нь 2015 оноос хойш сургуулийн тоо үлэмж нэмэгдсэнийг харуулж байгаа боловч сургуулийн хүрэлцээ удаан хугацаанд хангалтгүй хэвээр байна (UB Post, 2025). Хотын захад амьдардаг хамгийн ядуу хүүхдүүдийн сургуульд хамрагдах боломж хамгийн хязгаарлагдмал бөгөөд тэд сургуульдаа хүрч очих тээврийн зардлыг төлөх боломжгүй байж болно (Loo et al., 2022; Terbish et al., 2025). 2021 онд хийсэн, улсын хэмжээнд төлөөлөх чадвартай шилжин суурьшигчдын хэрэгцээний үнэлгээгээр шилжин суурьшигчдын тал орчим хувь нь боловсролын байгууллага хүртэлх зай, сургуулийн хүрэлцээ эсвэл сургуулийн багтаамжтай холбоотой асуудалд санаа зовниж байжээ (IOM Mongolia, 2022). Олон сургууль хоёр, гурван ээлжээр хичээллэдэг бөгөөд 1–12 дугаар ангийн 800,000 орчим суралцагчийн гуравны нэг нь хоёр эсвэл гурван ээлжээр хичээллэдэг сургуульд суралцаж байна (Монгол Улсын Боловсролын яам, 2025d).


ЗУРАГ 2:

Монгол Улсын дунд боловсролд дотуур байр чухал үүрэгтэй

a. Дотуур байранд орох хүсэлт гаргасан болон дотуур байранд амьдарч буй суралцагчдын тоо, Монгол Улс, 2010–24 он



b. Дотуур байранд амьдарч буй суралцагчдын тоо, хүйс, ангиар, Монгол Улс, 2024/25 оны хичээлийн жил



БХШ-ний статистик: https://bit.ly/GEM2026_Mongolia_fig2
Эх сурвалж: Монгол Улсын Боловсролын яам (2025b).

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй илүү нягт уялдаж, шууд санхүүгийн үр өгөөж хүртэх боломж олгож болох техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтад хөвгүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна. Есөн жилийн суурь боловсрол эзэмшсэний дараа суралцагчид тэтгэлэг олгодог, ажилд орох илүү тодорхой боломж бүрдүүлдэг мэргэжлийн боловсролын хөтөлбөрт хамрагдах боломжтой. Эдгээр хөтөлбөрт хамрагдаж буй 15–19 насныхны гуравны хоёроос илүү нь хөвгүүд, ялангуяа аж үйлдвэр, тээвэр, уул уурхай, барилгын чиглэлд суралцагчид байна.

Монгол Улсын боловсролын хууль тогтоомж дэвшилтэт шинжтэй. 1990-ээд оны эхэн үеэс дараалан батлагдсан хуулиудаар үнэ төлбөргүй, заавал эзэмших боловсролыг баталгаажуулж, хамрах хугацааг нь аажмаар 12 жил болгон сунгажээ (Engel et al., 2014). 2023 оны Боловсролын ерөнхий хуульд энэхүү зарчмыг улам бататгаж, ерөнхий боловсролыг 12 жилийн хугацаанд эзэмшихээр албан ёсоор тодорхойлсон байна (Монгол Улсын Засгийн газар, 2023). Гэвч хууль тогтоомж, бодлогод боловсрол дахь хөвгүүдийн боломж тааруу байгаад хангалттай анхаарал хандуулаагүй байна. Боловсрол хариуцсан орон нутгийн төрийн албан хаагчдын хэн нь ч жендэрийн асуудлыг боловсролын төлөвлөлт, хөтөлбөрт системтэй тусгах талаар сургалтад хамрагдаагүй, удирдамж, материалаар хангагдаагүй байна (Монголын Иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2024). Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021–2030)-д хөвгүүдийн боломж тааруу байдлыг тусгайлан авч үзээгүй байна (Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, 2020). Жендэрийн үнэлгээнүүд одоо ч голчлон охид, эмэгтэйчүүдэд төвлөрсөөр байна (World Bank, 2024). Боловсролын шударга тэгш байдал, үр ашиг, үр дүнг сайжруулах чиглэлээр хийсэн судалгаа, шинжилгээнүүд бүрэн дунд боловсролын түвшинд хүйсийн ялгаа байгааг хүлээн зөвшөөрдөг боловч бодлогын хувьд энэ асуудлыг тэргүүлэх чиглэл болгодоггүй (World Bank et al., 2020). Энэ асуудал өөрөө аяндаа шийдэгдэнэ гэсэн таамаг, буруу гэж үзэж болох таамаг байгаа бололтой.